

Мэдээ, мэдээлэл

“ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТОМИЛГОО” СЭДВЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

2020-05-06



Нээлттэй Нийгэм Форум (www.forum.mn) “Оюуны Инноваци” ТББ хамтран УИХ-ын хаврын чуулганаар Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулан Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх бодлогын цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж байна. Эхний хэлэлцүүлгийг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүний талаарх зохицуулалт” сэдвээр зохион байгуулсан бол хоёр дахь хэлэлцүүлгийг “Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо” сэдвээр зохион байгууллаа.

Энэхүү хэлэлцүүлэгт “Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо” сэдвийн хүрээнд “Оюуны-Инноваци” ТББ-ын гүйцэтгэх захирал, хуульч, судлаач П.Баттулга, Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн, хуульч, судлаач Л.Галбаатар, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор О.Мөнхсайхан, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар оролцож шинээр өргөн барьж буй хуулийн төслийн хүрээнд ямар өөрчлөлт орж байгаа талаар санал солилцсон юм.

Шүүхийн хараат бус байдлыг хангах асуудал нь шүүгчийн томилгоотой шууд холбоотой судлаачид хэлж байна. Шүүгчийн сонгон шалгаруулалтын үйл явцыг 1993-2012 он хүртэл хэсэгчлэн авч үзэж болох бөгөөд 2012 онд шүүхийн тухай багц хууль батлагдаж, шүүгчийн сонгон шалгаруулалтад тодорхой хэмжээний өөрчлөлтүүд орсон байна. 1993-2012 онд шүүгчийн сонгон шалгаруулалтад голлох үүрэгтэй оролцож байсан байгууллага нь Шүүгчийн мэргэжлийн хороо байжээ. Тус хороо нь шалгалт авч, тэнцүүлсэн нэр дэвшигчдээс Шүүхийн Ерөнхий зөвлөл нэр дэвшигчээ тодруулан Ерөнхийлөгчид санал болгодог байсан бол 2012 онд шүүхийн мэргэжлийн хорооны үнэлгээнээс гадна Монголын хуульчдын холбоо шүүгчид нэр дэвшигчдийн талаарх ур чадварын талаар дүгнэлт гаргадаг болсон нь томилгооны явцад ахиц гаргасан гэж үзэж буй юм.

Онцлох эшлэлүүд:



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.06

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо



**ХЗДХЯ-ны Хууль зүйн
бодлогын газрын дарга
П.Сайнзориг**

“ Ерөнхийлөгч Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох асуудлыг хуулийн төсөл дээр өөрөөр авч үзсэн.

Тухайн шүүгчдийн зөвлөгөөнөөс шүүгчид нь дотроосоо Ерөнхий шүүгчээ 3 жилийн хугацаагаар сонгож, нэг удаа улируулан томилох боломжтойгоор зохицуулья. Ерөнхий шүүгч нь өдөр тутмын зохион байгуулалтын үүрэгтэй ажилладаг тул шүүгч нар дотроосоо сонгох зохицуулалтыг дэмжиж байгаа.

Улсын дээд шүүхийн Танхимын тэргүүний асуудлыг Ерөнхий шүүгч шийдвэрлэхээр тусгасан. ”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.06

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо



МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн профессор,
хууль зүйн доктор
О.Мөнхсайхан

“

Шүүгчийг хуульчдаас шилж олох ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл гүйцэтгэх талаар Үндсэн хуульд тодорхой заасан. Гэтэл өнгөрсөн хугацаанд ШЕЗ энэ чиг үүргээ өөрөө бие дааж дангаараа хэрэгжүүлэх бус тусдаа Мэргэшлийн хороо байгуулаад, тус хороо нь шалгалт авдаг болсон.

Шалгалтаар хүмүүсийн байрыг оноогоор эрэмбэлээд нэрсээ ШЕЗ-д өгдөг. ШЕЗ тэдгээр нэрсэн дундаас мэргэжлийн хорооны эрэмбийг барихгүйгээр сонголт хийдэг. Үүнээс болж янз бүрийн хардлага, сэрлэг тасрахгүй байна.

Цаашид шүүгчийн сонгон шалгаруулах үйл ажиллагааг тодорхой болгож, хамгийн сайн шаардлага хангасан хүнийг шүүгчээр сонгох хэрэгтэй.

”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.06

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо

“



МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн профессор,
хууль зүйн доктор
О.Мөнхсайхан

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүдийг Ерөнхийлөгч томилдог нь маш ноцтой.

Ер нь шүүгчийн томилгоотой холбоотой эрх мэдлийг нэг субъектэд хэт төвлөрүүлж, хамаатуулах нь хамгийн аюултай. Тэр нь Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн альд нь ч байж болохгүй.

”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.06

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо



“Оюуны-Инноваци”
ТББ-ын гүйцэтгэх
захирал П.Баттулга

“ 1993 оноос өнөөдрийг хүртэл шүүгчийг сонгон шалгаруулах арга ажиллагаа 10 удаа шинэчлэгдэн батлагдсан. Энэ хугацаанд хамгийн гол маргаан дагуулаад байгаа нэг асуудал нь ШЕЗ-өөс шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох процесс дээр ойлгомжгүй, тодорхойгүй зүйл их гарч байна.

Тухайлбал, хамгийн өндөр оноо авсан хүн яагаад шүүгч болсонгүй вэ, түүнээс бага оноо авсан хүн яагаад шүүгч болов гэхчлэн хэл, ам их гардаг.

Дээрх асуудлыг зайлшгүй одоо хэлэлцэж байгаа Шүүхийн тухай хуулийн төслөөр тодорхой болгох шаардлагатай. ”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.06

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо

“ Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн төсөлд шүүгчийг сонгон шалгаруулах журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл Мэргэшлийн хороотой хамтран зохион байгуулахаар тусгасан.

Мөн Үндсэн хуулиар шүүгчийг шилж олох үүрэг хүлээсэн Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг томилуулахаар санал болгосон бол Ерөнхийлөгч татгалзахгүй томилох, томилохоос татгалзаж байгаа бол албан ёсоор саналаа хүргүүлэх зохицуулалт орсон байгаа.

”



Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн,
хуульч, судлаач
Л.Галбаатар



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.06

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо



МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн профессор,
хууль зүйн доктор
О.Мөнхсайхан

“

Үндсэн хуульд Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор шүүгчийг томилно гэсэн боловч харамсалтай нь монголын үе, үеийн Ерөнхийлөгчид уг асуудалд үзэмжээрээ хандаж, шүүгчид нэр дэвшигчээс татгалзах асуудал гарч байна. Энэ зүй бус нөлөөллийг саармагжуулах хуулийн зохицуулалт маш чухал юм.

Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох бүрэн эрх Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгоогүй. Энэ асуудлыг хууль тогтоогчид бодлогоор шийдэх хэрэгтэй. ”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.06

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо



ХЗДХЯ-ны Хууль зүйн
боллогын газрын дарга
П.Сайнзориг

“ Мэргэшлийн хороо шүүгчийн суурь болон тусгай шалгалтыг зохион байгуулах талаар төсөлд тусгасан. Онооны эрэмбээр шууд нэр дэвшигчдийг шалгаруулахаар маргаан гарч ирсэн.

Шүүгчийг сонгох асуудал нь мэдлэг ур чадварыг шалгахаас гадна, нөгөө талдаа шүүгч болох хүний ёс зүй, хандлага зэргийг авч үзэх шаардлага бий. Иймд Мэргэшлийн хороо шалгалтад тэнцсэн, тэнцээгүй гэдгийг дүгнэж Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгагдсан байгаа. ”